

13. Васубандху, Абхидхармакоша, Улан-Удэ, 1980,
14. **Неру Дж.**, Автобиография, М., 1955; Неру Дж, Взгляды на всемирную историю, т, 1—3, м, 1983; Неру Дж. , Открытие Индии, М., 1955; Моя жизнь, М, 1969,
15. **Радхакришнан С.**, Индийская философия, т. I—II, М., 1956; Рой М, История индийской философии, М., 1956; Чаттерджи С., Датта Д, Введение в индийскую философию М., 1955; Чаттопадхья Д. , Живое и мертвое в индийской философии, М., 1981,
16. **Гостеева Е. И.**, Философия ва йшешик, Ташкент, 1963; Лысенко Г. В.. . Атомизм школы вайшешика, Докт, дисс., М, 1981,
17. **Гусева Н. Р.** Джайнизм, М., 1968, Гусева Н, Р, Индуизм М, 1977
18. **Костюченко В. С.**, Вивеканда, М., 1977, Костюченко В. С., Классическая веданта и неоведантизм, М., 1983
19. **Исаева Н. В.** Из истории идейной борьбы в древней и раннесредневековой Ундии, канд. дисс, М, 1983,
20. **Жоль К. К.** Сравнительный анализ индийского логико-философского наследия, Киев, 1981, Андрасов В. П. Концепция ниришварада в Индийской философско-религиозной традиции, Канд, дисс, 1982. Кутасова И. И. Философия Нагарджуны, Канд. дисс, М, 1963,
21. Бонгард-левин Г. М., Древнеиндийская цивилизация, философия, религия, М, 1980, 156—208 дахь тал
22. Мөн зохиол. 208—242 дахь тал.
23. **Александров Г. Ф.** История социологических учений. Древний Восток, М. 1959, Александров Г. Ф. Очерки истории социальных идей в древней Индии, Минск, 1959.
24. **Аникеев Н. П.** О материалистических традициях в индийской философии, М, 1965, с. 128 — 199,
25. **Литман А. Д.** Современная индийская философия, М, 1985, с. 29.
26. **Бродов, В. В.**, Индийская философия нового времени, М., 1987.
27. **Корнев В. И.**, Буддизм и его роль в общественной жизни стран Азии М., 1983.

## **МОНГОЛЧУУДЫН ЭРТНИЙ СОЁЛ**

### **А. Дамдинсүрэн**

Та бидний өссөн төрсөн өлгий энэ Монгол нутаг бол өнө эрт үеэс эхлэн хүн төрөлхтний соёл иргэншил цогцлон бүрэлдэж буй болсон нэг том голомт юм. Түүнийг бүтээхийн тулд Монголчууд бидний өвөг Хүннү нар олон үеийн турш уйгагүй их хөдөлмөрлөн, оюун ухаан, хөлс цусаа үлэмж их асгаруулсан бартаат хэцүү зам туулан давж хүн төрөлхтний соёл иргэншлийн санд давтагдашгүй үнэт хувь нэмэр оруулан хойт үе бидэнд үүрд бахархан дурсаж явах сайхан өв үлдээсэн юм.

Энэ тухай гадаадын янз бүрийн орны эрдэмтэд, судлаачид Монгол оронд ирж Монголын уудам дэлгэр нутгийн хөрсөн доорхи болон дээрх түүх соёлын гайхамшигт дурсгалуудыг түүх, археологи, палеонтологи, геологи, угсаатан, хэл, утга зохиол, зан заншил, аж амьдралын байдлаар нь ангилан тал талаас нь нарийвчлан судалсан олон тооны ном, зохиолууд дэлхийн олон оронд янз бүрийн хэл дээр хэвлэгдэн гарсан билээ. Энэ олон эрдэмтэд, судлаачдын бичсэн судалгаа шинжилгээний ном зохиолд тулгуурлан үзвэл, Монгол оронд соёл иргэншил үүссэний

нэг том хэсэг болох мал аж ахуй чухам хэдийд, хаана анх үүсч, хэрхэн яаж тархсан зэрэг асуудлыг судлаачид нэгтгэн дүгнэж, цэгцтэй болгоогүй боловч хэсэг бусаг байдлаар судлан хөнджээ.

### 1. Монголын өвөг хэдийд үүсэв

Монголын өвөг Хүннү нарын нэр анх эртний Хятадын «түүхийн тэмдэглэл» гэдэг МЭӨ 145 оны үед бичигдсэн зохиолд 5 мянга шахам жилийн үйл явдлыг багтаан бичихдээ: «Хуан Ди, умарт, зүг Хүннүг мөрдөн хөөв» гэсэн байдаг. Энэ Хуан Ди бол Хятадын түүхэнд нэр гарч тэмдэглэгдэж буй хамгийн анхны овгийн ахлагч хүн бөгөөд МЭӨ 2550-аад жилийн өмнө байсан гэдэг домог бий. Иймд Хүннү, Хуан Ди хоёр бие биеийн эсрэг байсан нь Хятадын түүхэнд тэмдэглэгдэн үлджээ. Энэ үе бол Хүннү нарын дунд бас овгийн байгуулал үүсэж байсан цаг байх. Ер нь ямар ч гэсэн таван мянга шахам жилийн өмнө Хүннү гэдэг нэрээрээ энэ монгол нутаг дээр оршин тогтнож байхдаа явган байгаагүй, лав л унаа малтай болчихсон байсан. Энэ мэдээ бол Хүннү нарын тухай түүхийн хамгийн эртний мэдээ болж байна. Чухамдаа Хүннү нар бол Хятадын эртний түүхэнд тэмдэглэгдэхээс аль өмнө олон мянган жилийн турш энэ газар шороон дээр оршин амьдарч байсан нь ямар ч эргэлзээгүй.

Хүннү нарын тухай дээр өгүүлсэн түүхийн энэ мэдээг манай улсад сүүлийн жилүүдэд явуулсан генетикийн судалгаа нь Хүннү нарын оршин тогтнож байсан он цагийг их хэмжээгээр урагшлуулан давхар батлаж байна. Антропологийн шинжлэх ухаан үүссэн цагаас хүн төрөлхтнийг гурван том арьстан болгож хуваасны нэг нь Монгол хэмээх нэрээр Монгол төрхтнүүд гэж нэрлэгдэх болсон юм. Монголчуудын гарал үүслийг Азийн бусад Монгол төрхтнүүдтэй харьцуулан судлах явдал нэн чухал болжээ. Энэ талаар Биологийн ухааны доктор Ж. Батсуурь «Монголчуудын өлгий нутаг, гарал үүслийг генетикийн судалгаагаар мөшгөсөн нь» гэдэг бүтээлдээ; Алтай, Саяны орчмоор Монгол төрхтний зэрэгцээ **неолитын** үеэс нутаглаж байсан европ төрхтнүүдийн ул мөр Төв Ази-Сибирийн генийн газарзүйн голомтод байхгүй байгаагаас үзэхэд энэ голомтын төв неолитын өмнөх мезолит, аль эсвэл дээд палеолитын үед хамаарагдах үндэстэй, нөгөө талаас Монгол төрхтнүүдийн онцлог генүүд цугларсан генийн газарзүйн голомт түүхийн ямар ч үед хамаарагдлаа гэсэн Байгаль нуураар голчлон баруун-зүүн гэсэн хоёр хэсэгт хуваагджээ. Үүнээс үзэхэд, Төв Ази-Сибирийн генийн сангийн голомт бол монгол төрхтнүүдийн генийн сан бүрэлдэн тогтож эхлэх үед бус түүнээс өмнө дээд **палеолит** буюу түүний эхэнд хамаарагдах нь илүү магадлалтай гэж үзжээ. Энэ нь барагцаалбал 40000—12000 жилийн үед Монголын өвөг Хүннү нарын ген бүрэлджээ. Иймд Хүннүчүүдээс уламжлагдан ирсэн монголчуудын генийн сангийн голомт Байгаль нуураар голчлон Төв Азийн баруун зүүн жигүүрээр **Дээд палеолитын** эхэн үед салбарлан тархаж байсан Монгол төрхтнүүдийн генийн сангийн голомтуудын суурийн хооронд нь холбон үүссэн болохыг батлаад Монголчуудын генийн сан Хүннүчүүдээс өвлөн уламжилсан тухай баталгаанаас үзвэл генийн сан монгол угсаатны өнөөгийн нутагт тархах процесс нь таван үе шат тайгаар 2000 жилийн турш явагджээ гэж үзэх бүрэн үндэстэй. Эдгээр таван үе шатны нэг нь дундчаар 400 жил үргэлжилсэн гэж үзвэл эхнээсээ гуравдахь шат 1200 оны үед буй болсон буюу монгол уг

саатан бүрэлдэн тогтсон түүхэн үетэй таарч байна. Өөрөөр хэлбэл Монголчуудын генийн сан үүссэн өлгий нутгийн хүрээ аажим тэлэгдсээр түүхэн баримт мэдээгээр монгол угсаатан бүрэлдэн тогтсон гурван голын сав нутгийг XIII зууны эхэнд, хамарсан гэж үзжээ.

Энэ судалгаа нь Монголчуудын гарал үүслийг дээд палеолитын үед энэ нутаг дээр оршин амьдарч байсан Хүннүчүүдээс гаралтай гэдгийг гарцаагүй баталсан ажээ.

## **2. Монголд анх малыг гэрийн болгосон нь**

Монгол нутагт оршин амьдарч байсан Хүннү нарын дунд гарын дор бэлэн хоол, хувцас, хунар хийх арьс шир тэргүүтнийг бэлтгэж буй болгох зэрэг амьдралын зайлшгүй олон чухал шаардлагууд өдөр тутам нэмэгдэж байв. Агнуурын журмаар ашиглаж байсан хурдан хөлийн адгуус амьтан тэдэнд ойртож өгөхгүй бараагий нь хармагц зугатан зайлж алга болдог учир хэдэн хоногоор өл хоолгүй өлсөж үхэх явдал цөөнгүй тохиолддог болсон тул энэ хүнд байдлаас гарахын тулд 8—10 мянган жилийн үеэс эхлэн тэд нар эргэн тойрон байсан зэрлэг адуу, үхэр, хонь, ямаа, тэмээний дөнгөж гарсан нялх төлийг барьж авч тэжээх зэрэг янз бүрийн аргаар малтай ойртон ойртсоор биедээ дасган гэрийн болгожээ. Тэд бас зарим тохиолдолд хавцал хад, эрэг ганганд шахан хашиж биеэрээ тулан барьж авч сурган номхоруулж гэрийн болгож байжээ. Тэр үеийн хүмүүст ямар нэг бичгийн соёл бий болоогүй байсан тул тухайн үед болсон гол гол чухал үйл явдлыг хад чулуун дээр сийлэн үлдээдэг сайхан заншил ухамсарын биш зөн билгээр бий болсон байжээ.

Азид бий болсон гэрийн мал цаашид дэлхийн шинэ шинэ газарт түгэн тархсан байдлыг авч үзэхэд хүн төрөлхтөн Дорно зүг-Азиас өрнө зүг рүү нүүсэн нь гэрийн малыг тараахад чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

МЭӨ 4—5 мянган жилийн өмнө Азиас Европ руу нүүсэн зарим хэсэг хүмүүс нь гэрийн болгосон малтайгаа Европ орох замдаа Кавказ, Балкан, бага Азид үлдэн суурьшжээ. Энд ирсэн гэрийн мал нь шинэ орчин нөхцөлд зохицсон нутгийн мал болон уг гарсан төрх байдал, цаг агаар, хоол тэжээл, орчны байдлаас болж эрс өөрчлөгдөн шинэ шинэ үүлдэрүүд бий болон цааш хөгжжээ. Академич Е. Ф. Лискун болон Швейцарийн эрдэмтэн Л. Рютимейер нар эвэрт том малын удам-өвөг нь Азийн зэрлэг үхрээс гаралтай гэсэн байдаг. Адууг эрдэмтэд, судлаачид төв Ази-Монгол нутгаас гаралтай гэж үздэг. Үүнийг батлах баримт нь манай нутгаас эоцений үеийн адууны бүдүүлэг төрөл олдсон юм. Уг адуу энэ нутагт барагцаалбал 40 гаруй сая жилийн өмнө амьдарч байсан гэж үзээд адууны өвөг-удмыг хөлийн хурууны тоогоор нь үзэхэд гуравдагч галавын үе 5—30 сая жилийн өмнөх үеийн дөрвөн хуруутай зогипусаас нэг туурайт тахь болон хувирчээ. Орчин үеийн адууны зэрлэг уг удам нь манай одоогийн үе хүртэл явж ирсэн Монголын тахь гэж үздэг.

Хойт америкаас Плейстоценийн 650-аад мянган жилийн үеийн адууны чулуужсан яс олдсон нь Азиас очсон адууных болохыг тогтоожээ. Плейстоцены сүүл үед америкийн тэр адуу бүгд сөнөж дуусчээ. Хүннүгийн үед тахь, хулан, адуу, илжиг, луус зэрэг таван төрлийн адуутай байсан, МЭӨ 80-аад оны үеийн мэдээгээр Хүннү нарт луус,

илжиг, тэмээ олон байсан тухайг түүхэнд дурджээ. Адууг гэрийн болгох ажил төв Ази-Монгол нутагт эхэлж дараа нь Европт гэрийн болгосныг судлаачид зөвшөөрч байна. Адууны зэрлэг удам нь манай одоо үеийг хүртэл явж ирсэн Монгол тахь юм. 1879 онд оросын эрдэмтэн Пржевальский Монгол нутгаар жуулчлан явж байхдаа тахийг анх олж үзээд дэлхий дахинд танилцуулсан юм.

Түүнээс хойш 1898 оны хавар оросын худалдаачин Асановын анчид Власов, Захаров нар Монголын баруун говиос тахийн зэрлэг 6 охин тэр бүгд 7 унагыг барьж, 5 охин унагыг Бийск-д тэндээс нь Аскания-Нова-д явуулжээ, түүний нэг нь замдаа үхжээ. Энэ нь европт очсон хамгийн анхны тахь Монголын зэрлэг адуу байлаа.

Германы Карл Гагенбег зэрлэг амьтдыг худалдах ажлыг эрхэлдэг пүүсийн эзэн 1900 онд өөрийн ажилчин В. Григертийг Монголоос зэрлэг адуу-тахь барьж ирэхээр Монгол руу 1900 оны үед явуулж тахийн 15 эр, 13 охин унага авч германд очих замдаа 1 нь үхэж 27-ыг Гамбург-д авчраад 12-ыг нь Англи, бусдыг Франц, Голланд, АНУ д болон Германы амьтны хүрээлэнд худалдсан байна. Өнгөрсөн зууны сүүлчээр цэвэр үүлдрийн тахь 52-ыг сэлгэн нутагшуулахад, эхлээд 11-ийг Аскания-Новад аваачжээ. Тэдгээрийн 2 гүү, 1 азарга нь төллөх насандаа хүртэл амьдарснаас цэвэр адуу 37-ыг, эрлийз адуу 30 гаруй болтол өссөн байна.

Дэлхийн II дайн эхлэв. Германчууд Украиныг эзлээд 2 тахийг Германд аваачжээ. Бусад нь бүгд үхжээ. Дайн дуусахад ЗХУ-д тахь нэг ч үлдсэнгүй. Харин дайны дараа Прага, Германаас Аскания-Новад цэвэр үүлдрийн хоёр тахь, Монголоос тахины нэг азарга, нэг гүүг тус тус авчиржээ. 1964 оны эх болоход энэ амьтны хүрээлэн 7 тахьтай болжээ. ,

1950 онд тахийн том биш хоёр сүрэг (сүрэг тус бүр нь 12 толгой) Прага, Мюнхен дахь амьтны хүрээлэнгийн гол алдар суу нь болж байв. Мөн нас гүйцсэн хоёр тахь Английн Уипснейдийн амьтны хүрээлэнд, нэг хөгшин азарга Воберний амьтны хүрээлэнд байв. Түүнийг 54 жилийн өмнө унага байхад нь В. Григер Монголоос авчирсан нь Воберний амьтны хүрээлэнгийн тахийн сүргийг үндэслэгч болоод 1955 онд хөгширч үхжээ.

1958 оны сүүлчээр дэлхий дээр Монголын 56 зэрлэг адуу-тахь зориудын нөхцөлд амьдарч байсны дотор Прагад—13, Кэтскильд (АНУ)—10, Мюнхенд-6, амьтны бусад хүрээлэнгүүдэд 1-3 байв. Харин 1964 оны мэдээгээр дэлхийд манай монгол нутгийн алдарт адуу-тахь 109 толгой байснаа 1980 он болоход 385 толгой болон өсчээ.

Хамгийн олон тооны зэрлэг адуутай нь 40 орчим тахьтай Аскания-Новагийн дархан цаазтай газар юм. Тахийг хулан, бөхөн онц сайн нутагшиж чадсан Арал тэнгэсийн аглаг зэлүүд газар суурьшуулан нутагшуулах гэж төлөвлөж байгаа ажээ. Гадаадын амьтан судлаач-эрдэмтэд бичихдээ: тэнд тахийн сүрэг уугуул нутаг-Монголдоо байгаа юм шиг бараг тийм нөхцөлд Онгон зэрлэгээрээ бэлчээрлэх болно гэжээ.

1959 онд Прагад хуралдсан олон улсын симпозиум зэрлэг адуу тахийг ариглан хамгаалах, олон улсын нийгэмлэг байгуулахаар тогтжээ. Одоо манай улсад байгаа цөөн тооны тахийн сүрэг нь зарим үед өвс ус болон цаг улирлын тааламжгүй байдлаас болж идэш эрэн ул-

сын хилийг даван гарч орж байна. Эдгээр тахийг олж яаралтай хамгаалах арга хэмжээ авмаар байна.

Монгол-Зөвлөлтийн судлаачид палеолитын 40—12 мянган жилийн тэртээ үед хамаарагдах үеийн хадан дээр сийлсэн дурсгал манай орны баруун хэсэгт орших чандмань хар үзүүр, тэмээн хүзүү, ингэн толгой, хар үзүүр зэрэг газарт буй хадан дээр арслан, заан, савгат хирс, адуу, үхэр, гөрөөс, буга, аргаль, тэмээ зэргийг сийлсэн нь манай үед уламжлан иржээ. Энэ нь тэр үеийн хүмүүс аж ахуйдаа ашиглаж байсан буюу өдөр тутмын: практикт илүү ач холбогдолтой амьдралд нь нэн ойр зүйлийг сийлэн үлдээдэг байжээ. Үүнийг ажиглан харахад эртний хүмүүс малтай хичнээн их ойр байсны гэрч билээ.

Малыг гэрийн болгосон он цагийг орчин үед эртний судлалын янз бүрийн баримт материал олдвор зэргүүдэд тулгуурлан 8—10 мянган жилийн өмнө гэрийн болгосон гэж эрдэмтэд үзэж байна. Энэ нь өмнөх судлаачдын шинэ чулуун зэвсгийн үед мал гэрийн болсон гэж үзэж байсныг урагшлуулж мезолитын үе буюу 12—7 мянган жилийн үед гэрийн болгосон гэж үзэх нь илүү үнэмшилтэй болж байна. Харин шинэ чулуун зэвсгийн үед Монгол нутагт оршин суугчид нь нүүдэл ба хагас нүүдлийн хэлбэрээр амьдарч ан агнуур, үр тарианы үндэс түүх зэрэг аж ахуйн хэлбэрээс мал аж ахуй биеэ даасан салбар болон хөгжиж салсан байлаа.

Монгол нутгаас олдож байгаа палеолитын үеийн зурагт амьтны дүр зонхилж буй нь тохиолдлын зүйл биш, харин тэр үеийн хүмүүсийн эрхлэн амьдарч байсан ан агнуурын ажлаас тэдний амьдралын сайн сайхан өлсгөлөн зовлон зэрэг бүх зүйлд шалтгаалдаг байснаас амьтдын байдал, зан төрх, хүч чадал, амьдрах нөхцөл, тарга хүч энэ бүхнийг сайн мэдэж дүрслэх зайлшгүй шаардлага байжээ. Энэ тухай Академич А. П. Окладников: палеолитын урлаг зураг нь хүрээлэн буй бодит ертөнцийг эзэмшихэд идэвхтэй чиглэсэн юм. Амьтны амьдралд нэвтрэн орох, бодол санаагаараа амьтантай нэгдэх гэдэг бол ертөнцийг үзэх үзэл, сэтгэл зүйн гол чухал онцлог байснаас эртний чулуун зэвсгийн хүний бүхий л оюун санааны ертөнцөд том ул мөрөө үлдээсэн юм гэсэн байдаг.

Монгол орон бол хадан дээр мал ба амьтан сийлж үлдээсэн дурсгалаар туйлын баян орон юм. Энэ нь тухайн үед мал аж ахуй манай орны хүмүүсийн амьдралд онцгой чухал байр эзэлж байсны гэрч мөн. Тэдгээрийн дотроос зөвхөн Баянхонгор аймгийн Богд сумын ганцхан тэвш ууланд байгаа бүрэн биш авсан зургаар жишээ болгож үзэхэд: Морь унасан хүний дүрс 59, нум сум харваж байгаа морьтой хүн 4, дөрвөн морь хөллөсөн хоёр ба дөрвөн дугуйтай тэрэгний зураг 5, адууны дүрс 335 орчим, Баатар болон нум сумтай хүний дүр 20 гаруй тус тус байна.

### **3. Тэрэг, дөрөө анх хэрэглэсэн нь**

Манай орноос олдож байгаа хадан дээр сийлсэн тэрэгний зургийн он цагийг эрдэмтэд янз бүрээр тогтоож байна. Хэнтий аймгийн Батширээт сумын үзүүр цохио, Өмнөговь аймгийн ноён сумын нутагт буй тэрэгний зургийг МЭӨ III мянган жил, Хөвсгөл аймгийн Тэс суманд буй тэрэгний зургийг МЭӨ III—II мянган жил, Говь-Алтай аймгийн цагаан гол болон Дарви сумын нутагт буй тэрэгний зургийг МЭӨ

II-I мянган жил, Төв аймгийн Өндөр Ширээт сумын Уянгын үзүүрийн тэрэгний зургийг МЭӨ I мянган жилийн өмнөх үеийн бүтээл гэж үзэж байна. Иймд энэхүү тэрэгний зургийн талаар санал нэгдээгүй боловч уг тэрэг нь 3-5 мянган жилийн өмнө зурсан нь лавтай болсон юм. Үүгээр үзэхэд энд оршин суугчид 5 мянган жилийн өмнө малын хүчийг тэргэнд хөллөн ашиглаж сурсанаа чулуунд сийлэн үлдээдэг өвөрмөц заншил бидний өвгийн дунд нэн эрт үед бүрэлдэн бий болсны ул мөр нь олон мянган жил байгалийн янз бүрийн хатуу ширүүн үзэгдэлд арилаагүй давж ирсэн нь үнэхээрийн гайхамшиг.

Амьтан судлагчид, эрдэмтэд үзэхдээ: хүн адууг эхлээд идшинд хэрэглэж байснаа сүүлдээ гэрийн болгожээ. Адууг анх Азид гэрийн болгоод малыг унахын тулд эмээлийн дөрөөг зэрлэг хүмүүс бүтээсэн гэж бичсэн байдаг. Хүннү нар адууг гэрийн болгохын хамт түүнийг эдэлж хэрэглэх тоног төхөөрөмжийг цоо шинээр сэтгэн бодож бүтээгээд, түүнийгээ улам боловсронгуй болгон баяжуулж ирсэн нь сонин. Хүннү нарын дунд хазаарын амгай, эмээлийн дөрөө зэрэг нь МЭӨ III үед бий болчихсон байв. Энэ тухайн бодит баримт нь дуулга уул, Ноён уул зэрэг газарт нээсэн Хүннү нарын булшнаас эмээл, төмөр дөрөө, хазаарын төмөр амгай олдсон билээ. Европын хүмүүс эмээлгүйгээр удаан хугацаа өнгөрүүлжээ. Грек болон Ромын морьтонгууд морины нуруун дээр нөмрөг хаяж дээр нь мордоод байлдаанд ордог байв. Харин германчууд нөмрөг ч үгүй зайдан морь унадаг байсан. Тэдний ойлголтоор бол, зөөлөн дэвсгэр дээр суухаас илүү ичгэвтэр, хулчгар зүйл морь унасан хүнд байхгүй хэмээн Ромын цэргийн алдарт жанжин Юлий Цезарь (МЭӨ 100—44 он) хэлсэн байдаг. Энэ нь морь унасан хүн эмээл битгий хэл тохом хэрэглэхийг ч зэмлэсэн байдаг. Италид морь унах анхны сургуулийг үндэслэгч Пиньятелле XVII зууны үед амгайвчийг бодож олсон гэж бичсэн байдаг.

Дээр дурдсан баримтуудаас үзэхэд монгол нутагт Хүннү нар малыг гэрийн болгосон цагаас эхлэн мал маллах, малыг уналга, ачлага, чирэх татах болон тэргэнд хөллөх зэрэг янз бүрийн эдэлгээнд хэрэглэхэд зориулсан эмээл, хазаар, дөрөө, тэрэг тэргүүтнийг сэтгэн бодож бий болгон хэрэглэсэн явдал нь хүн төрөлхтний соёл иргэншилд оруулсан үнэт хувь нэмэр болсон нь дамжиггүй. Үүнийг орчин үеийн хүмүүсийн сэтгэхүйн өндөр төвшинтэй харьцуулан үзэхэд хэдийгээр энгийн хялбар зүйл юм. Харин хэдэн мянган жилийн өмнөх үеийн хүмүүс ийм зүйлийг сэтгэн бодож бүтээнэ гэдэг бол ихээхэн оюун ухаан зарцуулж бүтээх зүйл байсан нь илэрхий. Эмээл, хазаар, дөрөө, тэрэг зэргийн тус бүрийн зохион байгуулалт, бүтэц, онцлог, орсон материал, тэдгээрийг үйлдвэрлэх зэрэг нь эртний монголчууд хийгээд нийт нүүдэлчдийн оюуны болон эдийн соёлын хөгжилтэд хичнээн ач холбогдолтой байсныг уншигч та бүхэн надаар хэлүүлэлтгүй өөрсдөө эргэцүүлэн бодоод үзэцгээнэ үү. Хүннү нар нь малыг аж амьдралын олон салбарт өргөн хэрэглэж байв. Тэд малын арьс шир, ноос үсийг ашиглан янз бүрийн нэхмэл эдлэл, хувцас хунарыг чадамгай сайн хийж байсан олон баримт эдийн дурсгал археологийн судалгаагаар манай орноос олон олдсон. Сурвалж бичигт Хүннү нар малын махыг хүнсэнд хэрэглэхийн зэрэгцээ сүү цагаан идээг боловсруулан амтат идээ хийж байсны дотор цагаан архи хийж байсан гэж тэмдэг-

лэжээ. Мөн тэдний мал, түүнийг маллах арга ажиллагаа нь европ болон Азийн орнуудад тархсан билээ.

#### **4. Хүннүгийн мал маллах арга Азийн орнуудад дэлгэрсэн нь**

МЭӨ V зууны үед Хүннүгийн жороо морь, хоточ нохой болон хэрэглээний малыг Хятад худалдан авдаг байжээ. Хан улсын үед Хятад хүмүүс Хүннүгээс адуу мал их хэмжээгээр худалдан авч тариалангийн газар хагалахад зүтгэх хүчин болгон ашиглаж эхэлсэн нь Хятадын тариачдын олон мянган жил үргэлжилсэн биеэр хийдэг айхавтар хүнд хөдөлмөрийг малын хүчээр хийх болсон нь тэдэнд үнэхээр чухал ач холбогдолтой байсан ажээ. Ийм учраас Хан улс Хүннүгээс адуу зэрэг ажлын мал худалдан авч газар хагалахад болон цэргийн зориулалтанд ашиглах гэж адууг олноор авч, түүнийг маллах арчлах арга ухааныг сурах гэж их анхаарал тавьж байжээ. Хан улсын Чжин Ди хааны тэмдэглэлд (МЭӨ 156— 143 он) Хан улс Хүннүгээс авсан 360 мянган адууг 36 суурь болгон умард ба баруун хилийн районоор суурьшуулан маллаж байсан мэдээ бий, «Давс төмөрийн бодлого» гэдэг номын газар хагалбарлах хүч гэдэг бүлэгт Хүннүгийн луус, илжиг, тэмээ Хятад нутагт олон тоогоор орж ирж байсан хийгээд бас тахь худалдан авч байсан мэдээ буй. Хан улсад олзлогдсон Хүннүгийн Ван Суту нь бууж өгөөгүй учир алагдаж түүний эхнэр болон хүү Жидийг олзлон аваад түүний хүү Жидийг эцгийнх нь нэрээр овоглуулаагүй харин Сутугаас олзлон авсан «Алтан бурханы» «Алт», Хятадаар «Жин» гэдэг овгийг Жиди-д өгсөн учир Жин-жиди гэдэг нэртэй болгожээ. Тэгээд Хан улсын У Ди хаан болон ордныхон Жин жидигээр адуу маллах арга ухааныг заалгаж улмаар Жин-жиди нь Хан улсын адууны яамыг эрхлэн удирдаж, адуу маллах арга ухааныг Хятадад нэвтрүүлэх суурь эхийг анх тавьжээ. Ийнхүү Хүннүгийн мал маллах арга ухаан харь улс оронд нэвтрэн дэлгэрэхдээ адууны зарим нэр томъёо монгол хэлнээс Дорно зүгийн нэлээд орнуудад нэвтрэн орсон тухай хэл шинжлэлийн эрдэмтэд Хятад хэлний «Ма», «Кэ» нь Монгол хэлний «Морь», «гүү». Вьетнамд адууг «ма», «гүү»-г «гай» гэдэг, Япон хэлэнд «ума» гэж адууг хэлдэг, бас Солонгос зэрэг хэлэнд монгол хэлнээс адуу гэдэг үгийг зээлдэн авсан гэж үздэг.

Монголчуудын мал маллах сайхан уламжлалыг өрнөдийн судлаачид ч зөвшөөрдөг. Англи улсын нэгэн эмэгтэй эрдэмтэн Монголчууд шиг, мал маллах арга ухааныг гайхамшигтай хөгжүүлсэн өндөр соёлтой орон өөр хаана ч алга гэж бичсэн нь бий.

Мал аж ахуй хөгжсөний үр дагавраар малчин аймгууд бусад бүдүүлэг олноосоо ялгаран гарсан нь хөдөлмөрийн нийгмийн анхдугаар том хуваарь байжээ. Малчин аймгууд анчин, загасчин нараас илүү их юм бүтээдгээр барахгүй, амь зуухдаа үйлдсэн, юм нь ч ондоо байжээ. Малчин аймгийнхан сүү, цагаан идээ, мах шүүс элбэгтэйн дээр түүхий эдийн зүйл, ээрэх, нэхэхийн тоог бүр арвин болгосон шир, арьс, ноос, ямааны ноолуур тун ихтэй байжээ. Тэр нь анх байнга арилжаа хийх боломжийг бий болгожээ.

Хөдөлмөрийн нийгмийн анхдугаар том хуваарь гарсан нь эхийн эрхт овгийн байгууламжийн хэдэн мянган жилийн тогтуун байдлыг ганхуулжээ. Сүрэг мал, бусад баялаг эзэмдэхийн хамтаар, гэр бү-

лийн дотор хувьсгал гарчээ. Хамаг ажилд эрчүүд явж, ажлынхаа хэрэгслийг хийж, тэр нь эрчүүдийн өмч болдог байжээ.

Эрчүүд адгуусыг анх номхотгож аваад хожим тэдгээрийг маллах ажлыг мөн өөрсдөө хийдэг болжээ. Ийм учраас мал эрчүүдэд хамаатай бөгөөд бас малаар арилжиж авсан бараа, боол нь эрчүүдийн мэдлийн болдог байжээ. Тэр цагт ажлын бүтээлийн бүх илүүдэл нь эрчүүдэд оногдоод, эмэгтэйчүүд тэр илүүдлийг хэрэглэхэд оролцдог боловч өмчлөх хувь байдаггүй байжээ. «Анчин, гөрөөчин эрчүүд гэр бүлийн дотор эмэгтэйчүүдийн дараахь хоёрдугаар суурийг чуу чамай эзэлж байсан нь харин түүнээс «нилээд номой» малчин баялагтаа эрэмшиж, нэгдүгээр сууринд товойн гарч, эмэгтэйчүүдийг хоёрдугаар сууринд шахан оруулсан тухай Ф. Энгельс бичжээ.

Суурин Хятад улс, төв Азийн нүүдэлч ард түмэн хоёр өнө эрт цагаас харилцан адилгүй өвөрмөц соёл иргэншлийг биеэ даан бий болгож угсаа гарлын ба аж ахуй-соёлын ийм эрс өөр хоёр том голомт бүрэлдэн бий болж, эдгээр нь тус бүрдээ өвөрмөц эх үүсвэр, өөрийн гэсэн онцлог түүх, соёлтой одоо хүртэл явж иржээ.

Төв Ази, түүний дотор Монголын уудам дэлгэр нутагт язгуур үндэснээсээ уул нутгаас гаралтай балар эртний хүмүүс дээрх нутгийг хэзээнээсээ нааш эдлэн суурьшсаныг гэрчлэх хуучин ба шинэ чулуун зэвсгийн үеийн өвөрмөц соёл байсныг Монгол-Зөвлөлтийн археологчдын хийсэн шив шинэхэн нээлтүүд хөдлөшгүй нотлож байна.

Одоо манай орны хангай, говьд онгон зэрлэгээрээ байгаа хонины өвөг аргал, ямааны өвөг янгир тэмээний өвөг хавтгай, адууны өвөг тахь болон хулан зэрэг ховор амьтдаа анх үүссэн унаган байгальд нь айлгаж цочоохгүй аятай тавтай байлгаж, байгалийн хатуу бэрх үед өвс бордоо хаяж өгөх, булаг шандыг ухаж усжуулан туслаж тоо толгойг нь өсгөн олон болговол эх орны үзэсгэлэн гоо, баялагийг улам арвижуулна. Орчин үед дэлхийд ховордсон амьтад зэрлэгээрээ амьдарч байгаа газар тун цөөн. Ирээдүйд энэ амьтдаас нэг толгойг гадаадын амьтны хүрээлэнд худалдах юмаа гэхэд тун өндөр үнэ хүрнэ. Гэтэл манай нутагт анх байсан таван төрлийн адуунаас илжиг, луус тун цөөрчээ. Илжиг, луус эдэлгээнд сайн, ялангуяа илжиг нь адууны төрлийн дотроос хамгийн удаан хугацаагаар эдлүүлдэг, урт насалдаг онцлогтой мал. Монголын ард түмний өвгөөс мал гэрийн болгосон нь зөвхөн түүх болоод зогсохгүй, энэ нь хүн төрөлхтний соёлын санд бидний өвөг дээдсийн оруулсан асар их хувь нэмэр юм.

Манай орны малчид, мал аж ахуй дээр ажиллаж байгаа болон малын тал бүрийн сайхан өв тэгш ашиг шимийг ахуй амьдралдаа үргэлж амсан баясаж буй хүн бүр бидний энэ буянт малыг чухам хэдийд, хаана, ямар хүмүүс анх зэрлэг байхад нь гэрийн болгов гэдэг Дээрх асуултыг баримтаар үзэхэд уг үйл явдлыг бидний өвөг гардан хийжээ. Ийм учраас өвөг дээдсийн үлдээсэн энэхүү соёлын өв нь Та бидний нэгэн том бахархал билээ.